



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/116

Мандалговь

И-Оффис системийн байнгын ажиллагааг
хангахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Засаг даргын зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 20-ний өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн төрийн байгууллагууд болон сумдын хоорондын цахим сүлжээний болон цаг агаарын мэдээлэл, онцгой байдлын зарлан мэдээлэх И-Оффис системийн байнгын ажиллагааг хангахад хөрөнгө зарцуулсугай.

Хоёр. Дээрх арга хэмжээнд шаардагдах 5580000 (таван сая таван зуун наян мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Оффис системийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190325